

ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2025 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээ эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан тухайн эмчилгээний онцлог, мэргэжлийн олон асуудлуудыг зохицуулах бие даасан хууль боловсруулан гаргах хэрэгцээ шаардлага бий болсон бөгөөд хуулийн төслийг баталснаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж үйлчилгээний эрх зүйн орчин боловсронгуй болж, эмчилгээг тэгш, хүртээмжтэй, шударга байх зарчмыг баримтлан ажиллах, эмчилгээ үйлчилгээний шинэ арга технологи нэвтрүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн байна.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах хуулийн төслийн хүрээнд Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг шинээр байгуулах, тус байгууллагын хүний нөөц, урсгал зардалд нийт 1,9 тэрбум төгрөгийн зардал шаардлагатай гэж хууль санаачлагчид үзжээ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийг үндэслэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаарх хууль зүйн дүгнэлтийг ирүүлсэн.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ амьгүй донор болж эрхтэн, эд, эсээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож буй эмч, ажилчдыг эрсдэлээс хамгаалах асуудал хуулийн төсөлд хэрхэн туссан талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр ясны хэм, чөмөг авхуулж байгаа 14-өөс доош насны хүүхдүүд хэр олон байгаа болон одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Донорын тухай хуульд заасан хүүхдээс ясны хэм, үүдэл эс, чөмөг, хүйн цуснаас бусад эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглох заалт шинээр боловсруулсан хуулийн төсөлд яагаад тусгаагүй талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Сарнай хохирогч, хохироогчтой донорын талаар, хуулийн

төсөл батлагдсанаар шинээр бүтэц, орон тоо бий болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа хууль зүйн дүгнэлтийн хүрээнд гарсан саналыг хуулийн төсөлд тусгаж, сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хүүхдээс ясны хэм, үүдэл эс, чөмөг, хүйн цуснаас бусад эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглох заалтыг хуулийн төсөлд тусгах талаар тус тус санал хэлсэн.

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58,8 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 58,8 хувийн саналаар, Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг 64,7 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн бол, хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Л.ЭНХНАСАН

